

**Ордосын дугуйлангийн нэрт удирдагчийн нэг  
Ванданнэмын үйл амьдралаас**

*Элчин сайд, ахмад дипломатч О.Хосбаяр*

Ванданнэмын 1872 онд Өвөрмонголын Их Зуугийн чуулганы Вангийн хошууны Буудгийн шил хэмээх газар ядуу ард Түмэнбаярын ганц хөвүүн болон төржээ. Вангийн хошуу Ордос долоон хошууны хамгийн ахмад нь. Тус хошууны үе залгамжилсан засаг ноён бол Чингэсийн хойч үе болох Батмөнх даян хааны гуравдугаар хүү Гүнбилигт мэргэн жононгийн ууган хүү аж. Гүнбилигт мэргэн жонон есөн хүүтэй байсан бөгөөд тэднийг Ордос хошуудыг үе улиран захирах ноёд болгожээ. Иймд ууган хүүгийн эзлэн суусан хошууг ахмад гэж нэрлэх болсон байна. Ахмадын хувьд вангийн хошуу бусдадаа ихээхэн нөлөөтэй байжээ.

Ванданнэм 8 насандаа Вангийн хошуунаас засаг хошууны ламын сүмд гэгээнээр залагдан очжээ. Тэнд 8 жил түвд ном заалгаж бандид гэгээн цол хүртжээ. Тэр монгол, түвд, хятад хэл бичиг мэддэг байжээ. XX зууны эхэнд Манжийн Чин улсын засгийн газар “ардыг нүүлгэж хязгаарыг бэхжүүлэх” бодлого явуулж өмнө газраас олон тооны Хятад тариачдыг Ордос үүлгэн суурьшуулах болсон байна. Тэдгээр тариачид их хэмжээгээр атар хагалбарлаж малын бэлчээр багассанд нутгийн лам, хар олон түмэн ихэд дургүйцэн Чингийн бодлогыг эсэргүүцсэн ардын дугуйлангийн хөдөлгөөн өрнөх болжээ.

Ванданнэм хэдийгээр лам хувилгаан хүн боловч монголчуудын талаар Чин улсаас явуулж байсан түрэмгий бодлого болон нутгийн ван гүн, хар шар феодалын дарлал,

мөлжлөгийг үзэн яддаг байсан учир лам дээлээ орхин эсэргүүцлийн хөдөлгөөнд нэгдэн орж, Засаг хошуун дахь дугуйлангийн хөдөлгөөнийг толгойлох болжээ. Тэр улмаар Өвөр Монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцлийн олондоо алдартай, нэр хүнд бүхий удирдагчдын нэг болсон байна.

Ванданням ардын дугуйланг толгойлох болсон нь Засаг хошууны засаг ноён Шагдаржавын уур хилэнг бадрааж тэдний хоорондын маргаан, зөрөлдөөнийг улам хурцатгажээ. Ийм байдал Ванданнямд муугаар нөлөөлж болзошгүй гэж ойр дотны нөхөд нь үзэн хошуунаас түр гарч явахыг зөвлөсөн байна. Энэ ёсоор Ванданням 1906 онд өөрийн хоёр шавиа дагуулан засаг хошуунаас гарч Ордос Их Зуугийн чуулганы Хангин, Далд, зүүнгар зэрэг хошуугаар явж, нутаг орны байдалтай танилцжээ. Тэр ингэж явахдаа харц олонд ойр байж, элдэв зүйлийг лавлаж мэдэхэд дөхөм хэмээн бодож бандид хувилгаан ламын гарлаа нууж байсан байна.

Хангин хошуунд байхдаа уг хошууны дугуйлангийн удирдагч Цагаанболдтой ойр дотно танилцаж сайн нөхөд болжээ.

1908 онд Ванданням, Цагаанболдтой хамтран ардын дугуйлангийн зэвсэгт хүчийг зохион байгуулж Хатан голын /Шар мөрөн сав газраар партизаны дайн явуулж байжээ. Ингэж явахдаа Зүүнгар хошууны бүсгүй Окунтодтой ураглан гэр бүл болсон байна.

Энэ үеээр Ниншаа /Иргайт/ хотын цэргийн ерөнхий захирагч Ма Фусян Алшаагийн ноёдтой хуйвалдан Ванданням, Цагаанболд нарыг баривчилж хорихоор зэхэж байжээ. Ингээд 1913 оны 6 дугаар сарын 1-нд Ниншаагаас захидал илгээн Ванданямтай уулзаж зөвлөлдөх зүйл байгаа тул түүнийг Хатан голын хөвөөн дахь Цагаан тохой хэмээх газар хүрэлцэн ирэхийг урьсан байна. Ванданям товлосон өдөртөө хүрэлцэн очжээ. Усан онгоцон дээр гарч ирмэгц нь тэнд бүгэж байсан зэвсэгт цэргүүд буу тулган түүнийг баривчилсан байна. Ванданням баригдан, усан онгоцоор Хатан голыг уруудан Бугат хотын зүг явж байтал энэ тухай мэдээ авсан Цагаанболд түүнийг аврахаар хэдэн цэрэг дагуулан зам тосон очоод бас баригджээ. Энэ тухай Отгонбилэг бичихдээ: “Их зуугийн чуулганы дугуйлангийн алдарт удирдагч Ванданням, Цагаанболд зэрэг долоон хүнийг Ма Фусян хууран бариад Ванданнямыг Бээжинд аваачиж сул хорьсон, бусад зургааг нь Тайюэнд аваачиж алав” гэжээ.

Ванданнэмыг ийнхүү баригдан шоронд хоригдож байх үед дугуйлангийн зэвсэгт хүчийг ард нь хоцорсон гэргий Оюунтод нь толгойлон тэмцэл явуулсаар байжээ. Хятадын цэргийн эрхтнүүд зэвсэгт хүчээ татан буулгаж, гэргийгээ дуудан ирүүлсэн нөхцөлд амийг нь аврах болзол тавьсан Ванданнэ арга буюу хүлээн авчээ.

Ванданнэ, Цагаанболд нарыг шүүх явцад Ванданнэмын хувилгаан гаралтайг олж мэдээд Бээжингийн сонорт хүргэсэн байна. Удалгүй Юань Шикай засгийн ордноос ванданнэмыг Бээжинд түргэн хүргэх тушаал өгчээ. Ингээд Ванданнэ гэргийн хамт Бээжинд хүргэгдсэн байна.

Бээжинд Юань Шикай Ванданнэмыг өөрийн биеэр хүлээн авч ярилцахдаа түүнийг монголчуудын дунд өөрийн төлөөний хүн болгон тавих зорилгоор эрдэм мэдлэг, ухаан санааг нь магтан сайшаахын зэрэгцээгээр Монголын хутагт, хувилгаадын эрх ямба, нэр цолыг хуучин хэвээр үлдээхээ амлаж байжээ. ванданнэ ч хожмын үйл хэргээ бодож түүний аясыг дагахаар шийдсэн бололтой юм.

Ийнхүү Юань Шикай Ванданнэмыг “Цэргийн яамны зөвлөх” нэрийдлээр Бээжинд Юнь Хэгүн сүмийн ойролцоо гэрийн хорионд 13 жил байлгажээ. “Ванданнэ хоригдсон боловч цаг ямагт гаслан зовлон амсаж байгаа дугуйлангийн түмнээ ер мартсангүй бөгөөд... хэзээ нэгэн өдөр зэвсэг барьж ардаа дагуулан дайсантай тэмцэхийг хүсэн хүлээж байлаа.”<sup>2</sup>

1917 онд Орос оронд октябрын хувьсгал яллаа. Баруун гүрнүүдээс Хятадын талаар явуулж байсан түрэмгий бодлогыг эсэргүүцэн, тухайлбал японы “Хорин нэгэн зүйл бүхий” шударга бус гэрээг хүчингүй болгохыг шаардсан “Таван сарын дөрвөний хөдөлгөөн” хэмээн нэрлэгдсэн эсэргүүцлийн сүрт жагсаал цуглаан, ажил хаялт Бээжин, Шанхай зэрэг том хотуудад өрнөжээ. Хятадад эв хамт намын үзэл санаа нэвтрэн гүнзгийрэх болов. 1921 онд Монголд үндэсний ардчилсан хувьсгал ялж ардын засаг тогтлоо. Энэ бүхэн тэр үед Бээжинд байсан Ванданнэмд зохих нөлөөгөө үзүүлсэн байна.

Ванданнэ Бээжинд байхдаа Зөвлөлтийн дипломат Карахан, Коминтерний төлөөлөгчид, Монгол улсын Дорж, Насанбат зэрэг хүмүүс, Хятадын анхны эв хамтын үзэлтэн Ли Да Чжао зэрэг хүмүүстэй уулзаж Орос ба Монгол улсад ардын хувьсгал өрнөж байгааг олж мэджээ.

Уушин хошууны дугуйлангийн удирдагч Шинэлам буюу Өлзийжаргал, Ванданнэмын ухай олонтоо сонсож байсан

боловч нүүр учран золгож байгаагүй учир түүнтэй уулзаж дугуйлангийн хөдөлгөөний талаар зөвлөн ярилцахаар 1921 оны эхээр зориуд Бээжинд иржээ. Тэд Бээжинд уулзаж танилцсандаа ихэд баярлаж Ордос ардын дугуйлангийн хөдөлгөөний талаар удтал зөвлөн ярилцжээ. Энэ үед Өвөрмонголын ардын хувьсгалт нам байгуулах бэлтгэл ажлыг Ванданням гардан гүйцэтгэж байжээ.<sup>3</sup> Үүнтэй холбогдуулан хувьсгалын үзэл сурталд суралцуулахаар Улаанбаатарт хүн явуулах боломжийн тухай асуудлыг Ванданням хөндөж ярихад, Шинэлам явахад бэлэн байгаагаа мэдэгдсэн байна. Ингээд Шинэлам ба түүний хүү Гунгаа 16 хүн Уушин хошуунд цугларан 1924 оны намрын сүүлчээр Улаанбаатарын зүг морджээ. Ийнхүү “дотоод монголын Их зуугийн чуулганы Ордосын эрх чөлөөний хөдөлгөөний нэрт зүтгэлтэн Ванданнямын санаачилгаар дугуйлангийн хөдөлгөөний удирдагч Өлзийжаргал тэргүүтэй төлөөлөгчид Улаанбаатарт хүрэлцэн ирж МАХН-ын Төв Хороотой харилцаа тогтоон үндэсний эрх чөлөөний тэмцэлдээ дэмжлэг олж Монгол улсын нам ба цэргийн сургуульд Ордосын залуучуудыг суралцуулж эхэлсэн юм”<sup>4</sup> байна.

Ванданням өөрийн нөхдийг Монгол улсад явуулсны дараа Бээжин дахь Коминтерний төлөөлөгчөөр дамжуулан Монголын нам, засгийн удирдагчдад цахилгаан утас илгээж, Ордосын ардын дугуйланг төлөөлөн Шинэлам зэрэг хүмүүс Монголд очиж эв хамтын үзэл ба хувьсгалын онолд суралцахын хамт буу зэвсгийн тусламж хүсэх бодолтой байгааг мэдэгдээд уг хүсэлтийг хүлээн авч халуун туслалцаа үзүүлнэ гэдэгт итгэж байгаагаа илэрхийлсэн байна. МАХН-ын удирдлага уг хүсэлтийг ёсоор болгон хүлээн авч, Фэн Юйсянд явуулахаар бэлтгэж байсан зэвсгээс зарим хэсгийг илгээх болж, хожим нь Бугат хотод хүргэж өгчээ.

1925 оны 10 дугаар сарын 27-нд Чуулалт хаалганд ДМАХН-ын төлөөлөгчдийн анхдугаар хурал болж ДМАХН албан ёсоор байгуулагдсан байна. Энэ хуралд тус намыг үүсгэн байгуулагчийн хувьд Ванданням Бээжингээс очиж оролцжээ. Тус хурал дээр Ванданням, Шинэлам нар төв хорооны гишүүнээр сонгогдсон байна.

Энэхүү намын бүрэлдэхүүний талаар түүхийн ухааны доктор Л.Жамсран бичихдээ “Шинэ байгуулагдсан ДМАХН нь Үндэсний нэгдсэн фронтын шинжтэй тул бүрэлдэхүүний хувьд жигд биш байв” гээд Ванданням нарын зэрэг гишүүдийг “Үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэгчид”<sup>5</sup> хэмээн

тодорхойлжээ. Эдгээр хүмүүс үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэлдээ коминтерн, Зөвлөлт ба Монгол Улсыг түшиглэх чиг шугам баримталж байсан байна.

Ванданням, Шинэлам нар нам байгуулагдсаны дараа Ордост буцаж дугуйлангийн хөдөлгөөнийг намтай холбох талаар ихээхэн ажил зохиожээ. Гэгээний хувьд Ванданнямыг бишрэн шүтэж хүндэтгэдэг байсан Ордос нутгийн олон түмэн түүнд гүнээ итгэн намын эгнээнд олноор элсэн орсон байна. Үүний үр дүнд Ордосын дугуйлангийн хөдөлгөөн урьд өмнө үзэгдээгүй хүчтэй өрнөж зарим хошуунд ардын засаг байгуулагджээ.

ДМАХН-ын анхдугаар их хурлаар баталсан “Өвөрмонголын ардын хувьсгалт ба Өвөрмонголын цэргийн дарга нарын сургууль байгуулах тухай тогтоол”-ыг хэрэгжүүлэх зорилгоор Ванданням, Шинэлам нар идэр залуучуудыг лам, хар, тайж, харц хэмээн үл ялгаварлан Өвөрмонголын ардын хувьсгалт цэрэгт элсэн байлдагч болохыг уриалахын хамт цэрэг элсүүлэх ажлаар Их зуугийн чуулганы хошуудад хүн томилон явуулсан байна. Ингэснээр Ордос Их Зуугийн чуулганаас нийт 300 гаруй хүн Бугатад ирж цэргийн сургуульд оржээ.

Дээр дурдсан тогтоолыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хийсний дараа 1926 оны намар Өвөрмонголын ардын хувьсгалт цэрэг байгуулагдаж “Ванданням ерөнхий сийлэн болж Ли Юи Дэ дэд ерөнхий командлагчийн үүрэг эрхлэв... Энэ бол Өвөрмонгол орны монгол ард түмний ууган хувьсгалт цэрэг мөн. Энэ бол монгол ард түмний хувьсгалт тэмцэл нэгэнт Зэвсэгт тэмцлийн шинэ шатанд орсны шинж тэмдэг болно.”<sup>6</sup>

ДМАНХ-ын хүсэлтээр Зөвлөлт болон Монголоос Өвөрмонголын ардын хувьсгалт цэргийг зэр зэвсэг, хувцас хунар, хөрөнгө мөнгөөр дэмжиж байжээ.

Ванданнямыг хувьсгалт цэргийн ерөнхий захирагчаар томилогдсоноос хойш удалгүй Бугат хотод гоминданыхан түүнийг идээ будаанд урих нэрийдлээр урвагч зальхай этгээд Тогимод гэгчийг ашиглан хортой эм өгч хордуулан алсан байна. Энэ үед тэр 54 настай байжээ.

Шинэлам зэрэг хүмүүс Ванданнямын нас барсныг нууцлан шарилыг нь бууны хайрцагт хийж битүүмжлээд Бугатаас гарч Хатан голыг онгоцоор гатлан Ордос Их Зуугийн чуулганы Далд хошууны Вангийн Зуу хэмээх газар авч иржээ. Энд Ванданнямын нас барсныг нийтэд зарлан мэдэгдсэн

байна. Тэндээс Ванданьямын шарилыг хасаг тэргэнд ачиж хошууны бандид ламын сүмд авч ирэн хувьсгалт цэрэг, нутгийн олон түмний хамт гашуудан салах ёс гүйцэтгэжээ. Гашуудлын цуглаанд ДМАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчдээс /Сэрэндондов, Сайнбаяр зэрэг/ гадна Зөвлөлт болон БНМАУ-ын төлөөлөгчид оролцсон байна.<sup>7</sup>

### **Зүүлт тайлбар**

1,2. Отгонбилэг, Улсын дотоодын нэг, хоёрдугаар хувьсгалт дайны үеийн Дотоод монголын ардын хувьсгалт нам, “Монголын түүхийн тухай өгүүллүүд”, Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо 1981 он, 327-р тал.

3. Удангүлэг, Монгол үндэстний орчин үеийн цуут хүмүүс, Өвөрмонголын Тунлян хот, 1990 он, 263-р тал.

4,5. Л.Жамсран, МАХН Өвөрмонголын ардын хувьсгалт нам үүсч бэхжихэд тусалсан нь “Дорно дахины асуудал” сэтгүүл, 1991 оны № 1, 13-р тал.

6. Отгонбилэг, Улсын дотоодын нэг, хоёр дугаар хувьсгалт дайны үеийн Дотоод монголын ардын хувьсгалт нам, “Монголын түүхийн тухай өгүүллүүд”, Өвөрмонголын ардын Хэвлэлийн хороо, 1981 он, 349-350-р тал.

7. С.Нарсан, Ордос ардын дугуйлангийн хөдөлгөөн” Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо, 1989 он, 299-р тал.

### **Сянганы үнэн түүх\***

***Д.Батхүү***

Энд сүүлийн үед нилээдгүй анхаарал татаж байгаа Гонконгийг БНХАУ-д эргэн нэгдсэнтэй холбогдуулан тус арлын Англи-Хятадын түүхэнд хамаарах хэсгээс товч, мөн арлын нэрийн гарал үүслийн тухай, соёл боловсрол, ахуй амьдралын талаар цухас өгүүлэхийг зорив. Урд нь энэ талаар гарч байсан материалуудад үйл явдлын дарааллыг дурдсанаас бус, түүхэн учир шалтгааллыг хомс өгүүлсэн тул энэ тал дээр бас нилээдгүй анхаарахыг хичээлээ.

### ***Сянган хэмээн нэрлэсний учир***

БНХАУ-ын Гуандун мужтай Шэньчжэнь голоор хиллэсэн Синьцзе буюу Шинэ газар, өмнөд хятадын тэнгис дахь Цзюлуны хойг, Сянган арал орчмынхоо 235 жижиг арлын